

Гэрлэлт цуцлахтай холбоотой хүүхдийн асрамжийг тогтоох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь*

Баттулгын ОЮУНТУНГАЛАГ**

-
- I. Удиртгал
 - II. Онолын үзэл баримтлал
 - III. Монгол Улсын эрх зүйн зохицуулалт
 - IV. Гэрлэлт цуцлахтай холбоотой хүүхдийн асрамжийг тогтооход тулгамдаж буй асуудал
 - V. Харьцуулсан судалгаа
 - VI. Дүгнэлт, санал
-



* Энэхүү бүтээл нь Төв аймагт шүүх байгуулагдсаны түүхт 100 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын гавьяат хуульч Ч.Доржгочоо, М.Могноон нарын нэрэмжит "Шилдэг илтгэл" шалгаруулах уралдааны "Оюутан" ангилалд III байр эзэлсэн болно.

** Монгол Улсын их сургуулийн Хууль зүйн сургуулийн 5 дугаар түвшний оюутан.



**Гэрлэлт цуцлахтай холбоотой
хүүхдийн асрамжийг тогтоох эрх зүйн
зохицуулалтыг боловсронгуй болгох нь**

Батмүлгын ОЮУНТУНГАЛАГ *Монгол Улсын их сургуулийн
Хууль зүйн сургуулийн 5 дугаар
түвшний оюутан*

Хураангуй: Энэхүү судалгааны ажил нь Монгол Улсад гэрлэлтийг шүүхийн журмаар цуцлах үед хүүхдийн асрамж тогтоох болон хүүхэдтэй уулзах эрхийн эрх зүйн зохицуулалтыг судалж, түүнийг боловсронгуй болгох асуудлыг шинжлэхэд чиглэсэн болно. Судалгааны хүрээнд Монгол Улсын Үндсэн хууль, Гэр бүлийн тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай конвенц болон холбогдох бусад эрх зүйн актуудыг шинжилж, Шүүхийн шийдвэрүүдийг судлан практик хэрэгжилтийг үнэлэв. Түүнчлэн Бүгд Найрамдах Солонгос Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Бүгд Найрамдах Франц Улсын хүүхдийн асрамж болон хүүхэдтэй уулзах эрхийн эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судалж, Монгол Улсын зохицуулалттай харьцуулсан дүн шинжилгээ хийсэн.

Судалгааны үр дүнгээс үзэхэд Монгол Улсын эрх зүйн зохицуулалт нь хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангах зарчимд тулгуурлан хүүхдийн асрамжийг тогтоох үндсэн шалгуур, шүүхийн шийдвэр гаргах нөхцөл, хүүхдийн саналыг харгалзан үзэх боломжийг хуульчилсан байна. Мөн шүүхийн практикт хүүхдийн нас, хүмүүжил, амьдрах орчин, эцэг эхийн халамж, шинжээчийн дүгнэлт зэрэг хүчин зүйлсийг харгалзан хүүхдийн асрамжийн асуудлыг шийдвэрлэж байгаа нь тогтоогдов. Гэвч хүүхдийг асрамждаа аваагүй эцэг, эхийн хүүхэдтэй уулзах, харилцах эрхийг хэрэгжүүлэх журам, давтамж, хэрэгжилтэд хяналт тавих тогтолцоо болон зөрчлийг албадан хэрэгжүүлэх эрх зүйн механизм хангалтгүй байгаа нь хүүхдийн аль аль эцэг, эхтэйгээ харилцах эрхийг бүрэн хангах боломжийг хязгаарлаж байна.

Харьцуулсан судалгаанаас үзэхэд судлагдсан улс орнууд хүүхдийн уулзах эрхийг хэрэгжүүлэх нарийвчилсан журам, шүүхийн хяналт, хэрэгжилтийг хангах хариуцлагын тогтолцоог хуульчилсан бөгөөд энэ нь хүүхдийн эрхийг хамгаалах үр нөлөөтэй механизм болж байна. Иймд Монгол Улсад хүүхэдтэй уулзах эрхийн хэрэгжилтийг хангах тусгай журам бий болгох, шүүхийн шийдвэрийн биелэлтийг албадан хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, хүүхдийн асуудлаар мэргэшсэн шинжээч, сэтгэл зүйчийн оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.



Түлхүүр үг

Гэрлэлт цуцлах, шүүхийн журмаар гэрлэлт цуцлах, хүүхдийн асрамж тогтоох, хүүхдийн дээд ашиг сонирхол, уулзах эрх

I. УДИРТГАЛ

Сэдэв сонгосон үндэслэл, шаардлага

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Монгол Улсын Шүүхийн тайланг жил бүр гаргадаг бөгөөд Монгол Улсын хэмжээнд 2019 онд Гэр бүлийн эрх зүйн маргаантай холбоотой 4449¹ хэрэг хянан шийдвэрлэж байсан бол хамгийн сүүлд гарсан Шүүхийн тайлан буюу 2024 оны тоон мэдээллээр нийт 6520² гэр бүлийн эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэсэн байна. Статистикийн мэдээнээс үзэхэд гэр бүлийн тогтвортой байдал алдагдаж гэрлэлт цуцлалт нэмэгдэж байгаа нь эцэг, эхийн аль нэгнээс тусдаа амьдарч байгаа хүүхдийн тоо нэмэгдэх үндсэн шалтгаан болж байна. Үүний зэрэгцээ хүүхдийн асрамж, эцэг эхтэй уулзах эрх, хүүхдийн дээд ашиг сонирхлыг хамгаалах эрх зүйн зохицуулалт одоогийн Гэр бүлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид бүрэн хангагдаагүй, практикт хэрэгжилт нь дутагдалтай байна. Судалгааны үр дүнд хүүхдийн дээд ашиг сонирхлыг хамгаалах зарчимд тулгуурлан Монгол Улсын гэр бүлийн эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, практик хэрэгжилтийг боловсронгуй болгох талаар бодит санал, дүгнэлт гаргах боломж бүрдэнэ. Энэхүү судалгаа нь зөвхөн гэрлэлтийг шүүхийн журмаар цуцлах үед хүүхдийн асрамж тогтоох болон хүүхэдтэй уулзах эрхтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг судална. Харин эцэг, эхийн эрх хасах, хүүхэд үрчлэх, гуравдагч этгээдийн асрамжид шилжүүлэх асуудлыг судалгааны хүрээнээс хассан болно.

Сэдвийн судлагдсан байдал

Тус сэдвийн хүрээнд монгол хэл дээр Гэрлэлт цуцлахтай холбоотой хүүхдийн асрамж тогтоох асуудлын хүрээнд судалгааны дагнасан бүтээл харьцангуй ховор боловч хүүхдийн эрх, гэр бүлийн эрх зүй болон гэрлэлт цуцлалтын үр дагавартай холбоотой зарим асуудлыг хөндсөн эрдэм шинжилгээний бүтээлүүд бий. Тухайлбал, Ц.Ичинхорлоо, Ц.Алтанцэцэг нарын эрхлэн гаргасан "Гэрлэлт цуцлалт ба хүүхдийн эд хөрөнгийн бус эрхийг хамгаалах нь" өгүүлэлд гэрлэлт цуцлалтын улмаас хүүхдийн эрх, ашиг сонирхол хэрхэн хөндөгдөж буй асуудлыг авч үзэж, хүүхдийн эд хөрөнгийн бус эрхийг хамгаалах эрх зүйн зарим асуудлыг судалсан байна. Мөн А.Түвшинтөгс, Э.Золзаяа нар "Монгол Улсад гэр бүлийн дагнасан шүүх байгуулах хэрэгцээ шаардлага, бусад улс орнуудын туршлага" сэдэвт өгүүлэлдээ гэр бүлийн эрх зүйн маргааны онцлог, түүнийг шийдвэрлэх дагнасан шүүхийн хэрэгцээ шаардлагыг хөндөн судалж, хүүхэдтэй холбоотой маргааныг мэргэшсэн шүүхээр шийдвэрлэхийн ач холбогдлыг тодорхойлжээ. Түүнчлэн Д.Баярмаа "Гэр бүлийн эрх зүй дэх хүүхдийн тэргүүн дээд эрх ашгийг

¹ Шүүхийн ерөнхий зөвлөл, Монгол Улсын Шүүхийн тайлан, 2020, 224 дэх тал, <https://drive.google.com/file/d/1q4Q7p7zoewazochw1ZIB22zHjxbnhZWU/view>.

² Шүүхийн ерөнхий зөвлөл, Монгол Улсын Шүүхийн тайлан, 2024, 237 дахь тал, https://www.judcouncil.mn/site/news_full/15378.

хамгаалах зарчмын хэрэгжилт" сэдэвт бакалаврын судалгааны ажилдаа хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангах зарчмын эрх зүйн үндэс, хэрэгжилтийн асуудлыг судалсан байна.

Дээрх судалгаанууд нь хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангах болон гэр бүлийн эрх зүйн маргааныг шийдвэрлэхтэй холбоотой тодорхой асуудлуудыг авч үзсэн боловч гэрлэлт цуцлалтын дараах хүүхдийн асрамж тогтоох асуудал, хүүхэдтэй уулзах эрхийн хэрэгжилт, шүүхийн шийдвэрийн биелэлт болон түүнийг хангах эрх зүйн механизмын асуудлыг дагнан, иж бүрэн байдлаар судалсан бүтээл ховор байна. Иймээс энэхүү судалгаа нь гэрлэлт цуцлалтын үед хүүхдийн асрамж тогтоох болон хүүхэдтэй уулзах эрхийн эрх зүйн зохицуулалт, шүүхийн практикт тулгамдаж буй асуудлыг хүүхдийн дээд ашиг сонирхлын үүднээс судалж байгаагаараа өмнөх судалгаануудаас ялгаатай юм. Мөн энэхүү судалгааны гол судлах зүйл буюу гэр бүл цуцлахтай холбоотой хүүхдийн асрамж тогтоох болон гэрлэлт цуцлалтын дараа хүүхдийн уулзах эрхийн асуудлыг судалсан дараах ном, сурах бичгүүд байна. Үүнд:

Хүүхдийн асрамж тогтоох асуудлын талаар судалсан зарим бүтээл:

Судлаач А.Дугармаа (2016, 65 дахь тал) "Монгол улсын гэр бүлийн эрх зүй: Онол бодлого, сорил, нэр томьёо" бүтээлдээ гэрлэлт цуцлах хэргийг шийдвэрлэхэд хамгийн маргаантай асуудлын нэг нь насанд хүрээгүй хүүхдийн асрамж байдаг бөгөөд хүүхэд 7 насанд хүрсэн бол эцэг, эхийн хэний асрамжид байх талаар саналаа хэлэх ба энэ нь зөвхөн түүний саналаар хүүхдийн асрамжийн асуудлыг шийдвэрлэх нь учир дутагдалтай байна. Хүүхэд эцэг, эхээ өөрийн үзэл бодлоор бүрэн дүгнэж чадах эсэх нь анхаарах асуудалд хамаарна, зарим тохиолдолд хүүхдийг өсгөж, хүмүүжүүлэхэд гэрлэгчдийн эцэг, эхийн туслалцаа, хүүхэд өвөө, эмээдээ дассан байдлыг харгалзан тусдаа амьдрах эцэг, эхийн аль нэгэнд биш бусад этгээдэд хүүхдийн асрамжийг тогтоолгохоор хүсэлт гаргах асуудал практикт элбэг тухай дурдан гаргажээ.³ Мөн Судлаач Г.Баярдаваа (2007, 24 дэх тал) "Гэр бүлийн эрх зүйн харилцаа дуусгавар болоход хүүхдийн эрхийг хамгаалах нь" бүтээлдээ хүүхэд эцэг, эхийнхээ аль нэгнийх нь асрамжид үлдсэн ч нөгөө талын үүрэг нь Гэр бүлийн тухай хуулийн 26.4-т зааснаар хэвээр үргэлжилж байдгийг эцэг, эсхүл эх нь мэддэггүй бөгөөд зөвхөн тэтгэлэг төлөх үүрэг л өөрт нь үлдсэн гэсэн ойлголттой байдаг нь хүүхдийн эрх зөрчигдөх үндэс болдог. Иймд хүүхдийн асрамжийн асуудлыг шийдвэрлэхдээ хүүхдийн эцэг эхтэйгээ харилцаатай байх, эцэг, эхээ мэдэх, асран халамжлуулах, тэжээн тэтгүүлэх, туслалцаа авах зэрэг эрхийг хангах үүднээс шүүхийн шийдвэрт эцэг эхийн хүлээх үүргийг нэг бүрчлэн зайлшгүй тусгаж өгч байхаар Улсын Дээд шүүхийн тайлбар гаргуулах шаардлагатай гэж дурдсан байдаг.

Гэрлэлт цуцлалтын дараа хүүхдийн уулзах эрхийн асуудлыг судалсан зарим бүтээл:

Судлаач А.Батбаатар (2021, 97 дахь тал) "Гэр бүлийн эрх зүйн зарим асуудал" бүтээлдээ гэрлэлт цуцлалтын дараа үүсдэг тулгамдсан асуудлын нэг бол хүүхдийг төрсөн эцэг, эхтэй нь уулзуулахгүй байх тохиолдол их байна гэж

³ Авирмэдийн Дугармаа, Монгол Улсын гэр бүлийн эрх зүй: Онол, бодлого, сорил, нэр томьёо, (Улаанбаатар: 2016), 60–65 дахь тал.



дүгнэжээ. Иймээс эцэг, эхийн эрх, үүргээ хэрэгжүүлэхэд саад болохгүй байх үүргийг хуульчлах хэрэгтэй байна⁴ гэж үзсэн бол Сэтгэл судлаач Ц.Ганцэцэг (2017, 53 дахь тал) "Гэр бүл салалтаас үүссэн хүүхдийн түгшүүрийг проектив аргаар судалсан нь" бүтээлдээ гэрлэлт цуцлалтаас шалтгаалан хүүхдийн сэтгэл зүйд сөрөг асуудлууд үүсэн бий болдог ба гэрлэлт цуцлалтын дараа хүүхдэд үзүүлэх сэтгэл зүйн тусламжийг улс орны хэмжээнд энэ чиглэлээр мэргэжилтэн бэлтгэж, сэтгэл санааны эрх ашгийг нь хүндэтгэн хүүхдэд туслах арга замыг хайх ажил тулгамдаж байна гэсэн саналыг дэвшүүлжээ.⁵

Судалгааны зорилго

Энэхүү судалгааны гол зорилго нь Монгол Улсад гэрлэлт цуцлалтын улмаас үүсэх хүүхдийн асрамж, эцэг эхтэйгээ уулзах эрхтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг гүнзгий судалж, хүүхдийн дээд ашиг сонирхлыг хамгаалах, эцэг эхийн үүрэг хариуцлагыг тодорхой болгох, практикт тулгамдаж буй асуудлыг илрүүлэхэд оршино.

Судалгааны арга зүй

Энэхүү судалгааны ажлын бичихдээ хууль зүйн шинжлэх ухаанд түгээмэл хэрэглэгддэг харьцуулан шинжлэх арга болон эрх зүйн социологийн судалгааны аргууд болох задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх (анализ, синтез), баримт бичигт шинжилгээ хийх, тохиолдол шинжлэх аргуудыг тус тус ашиглалаа.

II. ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэгдсэн Үндэсний Байгууллагын Ерөнхий Ассамблейн чуулганаар 1989 онд батлагдсан, манай улс 1990 онд соёрхон баталсан "Хүүхдийн эрхийн тухай конвенци"⁶-ийн дагуу 18 насанд хүрээгүй хүн бүрийг хүүхэд гэх бөгөөд хүүхэд төрснөөр эцэг, эх, хүүхдийн хооронд эрх, үүрэг үүснэ гэж үзсэн байдаг. Хүүхдийн бие бялдар, оюун ухаан гүйцэд төлөвшөөгүйн улмаас түүнийг төрөхөөс өмнө болон төрсний дараа онцгой халамж, хамгаалалт шаардлагатайн зэрэгцээ тэд гэр бүлийн дотор аз жаргалтай, хайр халамжтай, бие биеэ ойлгодог нөхцөлд өсөж бойжвол өв тэгш хүмүүжиж, хөгжиж чадна. Тийм ч учраас эцэг эх, асран хамгаалагч нь хүүхдийн амьдрах эрүүл орчныг бүрдүүлэх, бие бялдын хувьд эрүүл чийрэг өсгөн хүмүүжүүлэх, хөгжүүлэх, нэн шаардлагатай хоол хүнс, орон байр, хувцас бусад зүйлээр хангах зэргээр хүүхдийн эрх ашгийг нэн тэргүүнд хамгаална.⁷

Орчин үед гэр бүлийг хүүхдийн нийгэмшлийн анхдагч орчин гэх үзэл баримтлал хүчтэй бий болжээ. Эцэг эх нь хүүхдийн хөгжлийн үе шат болгонд нас, сэтгэл зүйн онцлогт тохирсон оюун ухаан болон бие хүний дээд зэргийн

⁴ Алтангэрэлийн Батбаатар, Гэр бүлийн эрх зүйн зарим асуудал: Нэмж засварласан гурав дахь хэвлэл, (Улаанбаатар: 2021), 97 дахь тал.

⁵ Цэрэндамбын Ганцэцэг, Гэр бүлийн салалтаас үүссэн хүүхдийн түгшүүрийг проектив аргаар судалсан нь \6 настай хүүхдийн жишээн дээр\, Сэтгэл судлалын магистрын ажил, (Улаанбаатар: 2017), 53 дахь тал.

⁶ Хүүхдийн эрхийн тухай конвенц, 1989 он.

⁷ Авирмэдийн Дугармаа, Гэр бүлийн эрх зүй, (Улаанбаатар: 2016), 12 дахь тал.



хөгжлийг хангах нөхцөлийг бүрдүүлэх үүргийг нийгмийн өмнө хүлээсэн.⁸ Хүүхэд бүр төрсөн цагаасаа эхлэн хүний язгуур эрх, эрх чөлөөг эдлэх эрхтэй бөгөөд түүний эрх, ашиг сонирхлыг хамгаалах асуудал нь орчин үеийн эрх зүйт төрийн бодлогын чухал чиглэлийн нэг болж байна. Иймд улс үндэстэн, бүс нутаг болон олон улсын түвшинд хүүхдийн эрхийг хамгаалах үр нөлөө бүхий, цогц эрх зүйн болон институцийн механизмыг бүрдүүлэх асуудал төрийн бодлого, эрх зүйн зохицуулалтын анхаарлын төвд байсаар ирсэн байна. Хүүхдийн эрхийг хамгаалах үзэл санаа нь хүүхдийн эрх гэхээсээ илүү эцэг, эхийн үүрэгт их төвлөрдөг. Хүүхдийн эрх нь түүний эцэг, эхийн үүрэгтэй холбогдож хэрэгжих ёстой.⁹

Гэрлэлт цуцлалтын улмаас хүүхдэд бий болох сөрөг үр дагаврын талаар судалгаа хийдэг АНУ-ын эрдэмтэн Валлэрштейн судалгааны өгүүлэлдээ "гэрлэлт цуцлах явцад маргалдагч талууд болох хүүхдийн эцэг, эх нь өөрсдийн ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавьж хүүхдийн хэрэгцээ, хүсэл сонирхлыг үл ойшоодог. Гэрлэлт цуцлалтаас үүдэн хүүхдэд бий болох сөрөг үр дагаврыг урьдчилан тооцоолж, түүнийг хэрхэн даван туулах арга замыг тодорхойлсон эцэг, эхийн хооронд хийгдсэн гэрээ буюу төлөвлөгөөг үндэслэн гэрлэлт цуцлалтын маргааныг шийдвэрлэх хэрэгтэй" гэж үзсэн.¹⁰ Уг гэрээгээр хүүхдийн талаар эцэг, эхийн баримтлах зарчмыг тодорхойлж, үнэн зөв мэдээлэл өгөх, хүүхэд эцэг, эхтэйгээ байнгын харилцаа холбоотой байх нөхцөл, бололцоог бүрдүүлэх, хүүхэдтэй холбоотой бусад асуудлыг хэрхэн үр дүнтэй шийдвэрлэх, хүүхдийн боловсрол, эрүүл мэнд болон бусад зардлыг хэрхэн хариуцах зэрэг харилцааг зөвшилцөн шийдвэрлэдэг байна.¹¹

"Гэрлэлт цуцлалт нь эцэг, эхийг нь хүүхдийн тэтгэлэг төлөх үүргээс чөлөөлөхгүй ч хүүхдээ хүмүүжүүлэх арга барилыг өөрчилдөг. Хүүхдийн асрамж тогтооход голчлон хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангах зарчмыг үндэслэн, олон янзын хүчин зүйлийг иж бүрэн харгалзан үзвэл зохино." Мөн хүүхдийн асрамж тогтоох тухай эцэг, эхийн нэг талын асрамж болон хамтын асрамжийн загварыг хамтаар хэрэглэх нь үндэслэлтэй гэсэн байр суурийг олон улсын зарим судлаачид илэрхийлсэн байдаг.¹²

Шүүх гэрлэлт цуцлалтын маргааныг хянан шийдвэрлэхдээ хүүхдийн амьдрах орчин, эдийн засгийн нөхцөл, амьдралын чанар, сэтгэл зүйн байдал, эрүүл мэнд, хүмүүжилд үзүүлэх нөлөөллийг харгалзан үзэж шийдвэр гаргах нь гэр бүл цуцлалтын улмаас хүүхдийн эрх, ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх ач холбогдолтой бөгөөд хүүхэд хамгааллын талаарх нийгмийн хандлагыг төлөвшүүлэхэд чухал үүрэгтэй юм.

⁸ Төмөрийн Батцэнгэл, Батын Бандихүү, Гэр бүлийн сэтгэл судлал, (Улаанбаатар: 2012), 81 дэх тал.

⁹ Hilaire Barnett, (2021), Children's Rights and the Law: An Introduction 1st Edition, <https://www.perlego.com/book/2977126/childrens-rights-and-the-law-an-introduction-pdf>.

¹⁰ Wallerstein, J.S. (1985b). The Overburdened Child: Some Long-term Consequences of Divorce, Columbia Journal of Law and Social Problems, 19 (2), 165-182. <https://scispace.com/papers/the-overburdened-child-some-long-term-consequences-of-divorce>.

¹¹ Washington State Parenting Act (1987).

¹² Marie Julie, 2023, Family Rights 5 Protecting the Best Interests of Children: Family Law and Child Welfare, https://www.researchgate.net/publication/396053038_Family_Law_and_the_Best_Interests_of_the_Child_Standard_Developing_Incorporating_the_Mental_Health_Cultural_History_and_the_Voice_of_the_Child_in_Custody_Determinations.



Мөн шүүх нь гэрлэлт цуцлах маргааныг хянан шийдвэрлэхдээ хүүхдийн асрамжийг тогтооход юуг баримтлах талаар Монгол Улсын судлаачид ч бас өөрсдийн байр суурийг илэрхийлсэн байдаг. Шүүхээс хүүхдийн асрамж тогтоох асуудлыг шийдвэрлэхэд сурган хүмүүжүүлэгч, сэтгэл зүйч мөн өөр нарийн мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулж дүгнэлт гаргуулах нь чухал нөлөөтэй бөгөөд асрамж тогтоох асуудлыг шийдвэрлэхэд "Хүүхдийн саналыг харгалзах, санал авах журам"-ыг гарган ашиглах ёстой талаар дурдсан.¹³ Мөн хүүхдийн саналыг авахдаа сурган хүмүүжүүлэгч, эсхүл сэтгэл зүйчийг байлцуулан хүүхдийн гаргаж буй санал нь жинхэнэ хүсэл зоригийнх нь илэрхийлэл байж чадаж байгаа эсэхийг анхаарах ёстой бөгөөд энэхүү саналыг шүүх харгалзан үзэх ёстой талаар тодорхойлсон. Гэхдээ хүүхдийн асрамжийг тогтоох асуудлыг шийдвэрлэх цорын ганц үндэслэл болохгүй гэж үзжээ. Шүүх гэрлэлтийг цуцлах үед хүүхдийг зөвхөн эцэг, эхийн хэнийх нь асрамжид үлдээхийг шийдвэрлэх ёстой бөгөөд гуравдагч этгээдийн асрамжид үлдээхээр шийдвэрлэж болохгүй. Харин эцэг, эх нь онцгой нөхцөл байдал тогтоогдвол хүүхдийг гуравдагч этгээдийн асрамжид үлдээх шийдвэр гаргаж болно зэргийг дурдсан байна.¹⁴

Ийнхүү онолын болон судалгааны бүтээлүүдээс үзэхэд хүүхдийн асрамжийг тогтоох асуудал нь зөвхөн эцэг, эхийн хоорондын маргаан биш, харин хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах эрх зүйн цогц зохицуулалт шаардсан харилцаа болох нь харагдаж байна. Гэвч Гэр бүлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид хүүхдийн хууль ёсны төлөөлөгчийн хүлээх үүргийг хуульчилсан хэдий ч гэр бүлийн орчин дахь хүүхдийн эрх зүйн байдлыг нарийвчлан тодорхойлоогүйгээс хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй, улмаар хүүхдийн эрх, хамгааллын асуудалд хайхрамжгүй хандах хандлага бий болоход нөлөөлж байна.

III. МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Монгол Улсын Үндсэн хуулийн¹⁵ 16 дугаар зүйлийн 11 дэх хэсэгт "улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх няхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална" хэмээн, 17 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх нь иргэн бүрийн журамт үүрэг мөн" хэмээн хуульчилсан. Монгол Улсын Үндсэн хуулийн дээрх зохицуулалтууд нь гэр бүлийн харилцааны үндсэн зарчмыг тогтоож, гэрлэсний дараа үүсэх эрх зүйн үр дагавар, гэр бүлийг хамгаалах эрх зүйн зохицуулалтын суурийг бүрдүүлэхийн зэрэгцээ эцэг, эхийн хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх үүргийг иргэний журамт үүрэг болгон хэмээн нэрлэсэн. Ингэснээр хүүхдийг гэр бүлдээ ямар нэгэн дарамт шахалтад орохгүй, аюулгүй байх боломжийг хангаж өгсөн байна.

¹³ Цэндийн Алтанцэцэг, Гэр бүлийн эрх зүй, (Улаанбаатар: 2007), 28 дахь тал.

¹⁴ Чимэдийн Отгонбаяр, Гэр бүлийн эрх зүй, (Улаанбаатар: 2006), 37–38 дахь тал.

¹⁵ Монгол Улсын Үндсэн хууль (1992).



Монгол Улсын Гэр бүлийн тухай хууль¹⁶ нь гэрлэх, гэрлэлтийн харилцаа дуусгавар болох, гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус харилцаа, хүүхэд үрчлэх, гэр бүлдээ асран хүмүүжүүлэх, тэжээн тэтгэх, асран хамгаалах, харгалзан дэмжих үйл ажиллагаатай холбоотой үндсэн гол харилцааг зохицуулдаг. Гэр бүлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5 дахь хэсэгт "Хүүхдийг гэр бүлийн дотор эрүүл чийрэг өсгөн хүмүүжүүлэх, хөгжүүлэх, түүний эрх, ашиг сонирхлыг нь нэн тэргүүнд хамгаалахыг эрхэмлэнэ" хэмээн хүүхдийн тэргүүн дээд эрх ашгийг хамгаалах зарчмыг тусгасан. Тус хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Монгол улс нь гэрлэлтийг "захиргааны буюу шүүхийн журмаар" цуцалдаг. Гэрлэгчид гэрлэлтээ шүүхийн журмаар цуцлахдаа "хүүхдээ хэний асрамжид үлдээх ... тухайгаа бие даан, эсхүл эвлэрүүлэн зуучлалын журмаар харилцан тохиролцож болно" гэж заасан бөгөөд хэрвээ гэрлэгчид харилцан тохиролцоогүй бол "хүүхдийн нас, эцэг, эхийн халамж, ахуйн нөхцөл, бололцоо, ёс суртахууны байдал, хүчирхийлэл үйлдсэн эсэхийг нь харгалзан хүүхдийг эцэг, эхийн хэн нэгний асрамжид үлдээх ... асуудлыг шүүх шийдвэрлэнэ" хэмээн Гэр бүлийн тухай хуульд зохицуулсан байдаг.

Тус хуулийн 14 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт "Хүүхэд долоо ба түүнээс дээш настай бол асрамжийн асуудлыг шийдвэрлэхэд түүний саналыг харгалзан үзнэ" гэж заасан. Гэр бүлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2-т зааснаар эцэг, эх нь хүүхдээ эрүүл чийрэг өсгөн бойжуулах, сэтгэхүйн хувьд төлөвшүүлэх, үндэсний ёс заншил, уламжлалаа дээдлэх үзлээр хүмүүжүүлэх, түүнд суурь боловсрол эзэмшүүлэх, хөдөлмөрийн анхны дадлага олгох, хүүхдийн эрхийг хамгаалж, үүргээ биелүүлэхэд нь туслахаас гадна хүүхдээ асран хамгаалах, тэжээн тэтгэх үүрэгтэй.¹⁷ Шүүх гэрлэлтийг цуцалж, насанд хүрээгүй хүүхдийг эцэг, эхийнх нь хэн нэгний асрамжид үлдээж, нөгөө талаас тэтгэлэг гаргуулахаар шийдвэрлэж буй нь эцэг, эхийн хүүхдээ асран хамгаалах, тэжээн тэтгэх үүргийг хуваарилан хувааж буй асуудал биш юм. Гэрлэлтээ цуцлуулсан эцэг, эхийн хүүхдээ асран хамгаалах, тэжээн тэтгэх үүрэг хэн алинд нь хэвээр хадгалагддаг.¹⁸ Өөрөөр хэлбэл, гэрлэгчид нь гэрлэлтээ цуцлуулснаар эхнэр, нөхөр байхаа болих боловч эцэг, эх хэвээр үлддэг учир эцэг, эх байх эрхийг нь хуульд зааснаар хасаагүй тохиолдолд тэдгээрийн эрх, үүрэг хязгаарлагдахгүй болно.¹⁹

Хүүхэд гэр бүлдээ эрүүл өсөж бойжин эцэг, эхтэйгээ хамт амьдрах, тэдний анхаарал халамжид байх эрх нь хүүхдийн эрхийн талаарх олон улсын гэрээ, конвенц болон үндэсний хууль тогтоомжид заасан хүүхдийн бусад эрх баталгаатай хангагдах үндсэн нөхцөлийг бүрдүүлдэг. Ийм ч учраас Хүүхдийн эрхийн тухай конвенцын²⁰ 18.1-д "Хүүхдийн хүмүүжил болон хөгжилд эцэг, эх буюу тодорхой тохиолдолд хууль ёсны асран хамгаалагчид гол хариуцлагыг хүлээнэ" гэсэн заалт нь нэн тэргүүнд хүүхдийн эрхийг хангах үүднээс эцэг, эхийн хуулиар хүлээсэн үүргийг заавал хэрэгжүүлж байх шаардлагатай болохыг харуулж байна.

¹⁶ Гэр бүлийн тухай хууль (1999).

¹⁷ Улсын дээд шүүхийн 2017 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 03 зөвлөмж, "Гэр бүлийн холбогдолтой эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд анхаарах зарим асуудал", <http://old.supremecourt.mn/act/view/244>.

¹⁸ Мөн тэнд.

¹⁹ Мөн тэнд.

²⁰ Хүүхдийн эрхийн тухай конвенц (1989).



IV. ГЭРЛЭЛТ ЦУЦЛАХТАЙ ХОЛБООТОЙ ХҮҮХДИЙН АСРАМЖИЙГ ТОГТООХОД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

Дээрх зохицуулалтаас үзэхэд Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд хүүхдийн асрамжийг тогтоох асуудлыг талууд харилцан тохиролцох, тохиролцоонд хүрээгүй тохиолдолд шүүх шийдвэрлэхээр хуульчилсан бөгөөд шүүхээс хүүхдийн нас, эцэг, эхийн халамж, ахуйн нөхцөл, бололцоо, ёс суртахууны байдал, хүчирхийлэл үйлдсэн эсэх зэрэг нөхцөл байдлыг харгалзан үзэж шийдвэр гаргахаар зохицуулжээ. Мөн долоо ба түүнээс дээш насны хүүхдийн саналыг харгалзан үзэхээр хуульчилсан нь хүүхдийн оролцоог хангах нэг хэлбэр болж байна. Гэвч хүүхдийн асрамж тогтоосны дараах хүүхэдтэй уулзах эрхийг хэрэгжүүлэх журам, уулзалтын давтамж, хэлбэр, уулзах эрхийг хэрэгжүүлэхэд үүсэх маргааныг шийдвэрлэх механизм зэрэг харилцааг нарийвчлан зохицуулсан эрх зүйн зохицуулалт хангалтгүй байна. Иймээс практикт хүүхэдтэй уулзах эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой маргаан түгээмэл гардаг боловч түүнийг шийдвэрлэх эрх зүйн тодорхой механизм дутмаг байгаа нь хүүхдийн эрх, ашиг сонирхол бүрэн хангагдахгүй байх нөхцөл болж байна.

1. Гэрлэлт цуцлахтай холбоотой хүүхдийн асрамжийг тогтоох эрх зүйн зохицуулалтын шүүхийн практик дахь хэрэгжилт:

Жишээ 1. Шүүхээс хүүхдийг эхийн асрамжид үлдээсэн кейс

2021 оны 12 сарын 07-ны өдрийн Улсын Дээд Шүүхийн хуралдааны 01479 дугаар тогтоолоор²¹ нэхэмжлэгч М.Г болон хариуцагч Г.Г-д холбогдох Гэрлэлт цуцлуулах, хүүхдийг өөрийн асрамжид үлдээх, хүүхдийн тэтгэлэг тогтоолгох тухай нэхэмжлэлтэй иргэний хэргийг хариуцагчийн гаргасан гомдлын дагуу хянан шийдвэрлэсэн.

Хариуцагчийн гаргасан гомдол (хүүхдийн асрамж болон уулзах эрхтэй холбоотой): Би охиндоо эцгийн хайр халамжаа зориулах гэсэн ганцхан бодолтой. Надад ийм боломж хуулиар үгүй, би охиныхоо хувьд хамт байх уулзах ч шаардлагагүй, зөвхөн тэтгэвэр төлөгч юм байна гэж ойлгогдлоо. ... Охин *****-ийг аавтайгаа уулзаж байх өдөр цагийг тодорхой зааж өгнө үү гэсэн агуулгатай гомдлыг гаргасан.

УДШ-ээс гомдлыг хангахгүй орхиж охиныг үргэлжлүүлэн эхийн асрамжид үлдээхээр шийдвэрлэсэн бөгөөд тухайн шийдвэрийн үндэслэх хэсэгт дараах зүйлсийг тусгасан. Үүнд:

- Шүүх хүүхдийн асрамжийн асуудлыг шийдвэрлэхдээ хүүхдийн нас буюу бага насны, эсхүл насанд хүрээгүй байдал, цэцэрлэгт хүмүүжиж, эсхүл сургуульд сурч байгаа зэргээс шалтгаалан тухайн насны хүүхдийн хөгжил, хүмүүжлийн онцлогийг харгалзан үзэх ёстой.
- Өөрөөр хэлбэл хүүхдийн хүмүүжил, эрүүл мэндэд тавих анхаарал, хүүхдийн өсөж бойжих орчин, орон сууц, эд хөрөнгийн байдал, эцэг, эхийн өөрсдийн хүмүүжил, боловсрол, хүүхдийн болон гэр бүлийн бусад гишүүдийг эд хөрөнгийн хийгээд сэтгэл санааны дарамтад байлгадаг эсэх зэргийг шүүх анхаарч хүүхдийн асрамжийг тогтооно.
- Шүүхээс хэрэгт цугларсан нотлох баримтын хүрээнд дүгнэлт хийж хүүхдийн асрамжийг шийдвэрлэхдээ хүүхдийн нас, эцэг, эхийн хайр халамж, ахуйн нөхцөл бололцоо болон хүүхдийн санал, 2015 оноос хойш эхийн асрамжид байгаа зэргийг харгалзан 2009.09.13-ны өдөр төрсөн охин *****-ийг эх *****-ийн асрамжид үлдээсэн.
- Гэрлэгчид гэрлэлтээ шүүхийн журмаар цуцлуулснаар эхнэр, нөхрийн эрх, үүрэг дуусгавар болж байгаа бөгөөд харин тэдний эцэг, эхийн хувьд эдлэх эрх, хүлээх үүрэг хэвээр үлдэх тул хэн аль нь эдгээрийг зөрчихгүй байх үүрэгтэй.

²¹ Улсын дээд шүүхийн 2021 оны 12 сарын 07-ны өдрийн 001/XT2021/01479 тогтоол, <https://shuukh.mn>

Жишээ 2. Шүүхээс хүүхдийг эцгийн асрамжид үлдээсэн кейс

2024 оны 06 сарын 18-ны өдрийн Улсын Дээд Шүүхийн хуралдааны 00142 дугаар тогтоолоор²² нэхэмжлэгч Д болон хариуцагч Х-д холбогдох Хүүхдийн асрамж тогтоолгож, тэтгэлэг гаргуулах тухай нэхэмжлэлтэй иргэний хэргийг нэхэмжлэгчийн гаргасан гомдлын дагуу хянан шийдвэрлэсэн.

Нэхэмжлэгчийн гаргасан гомдол (хүүхдийн асрамж болон уулзах эрхтэй холбоотой): ... охинтойгоо уулзах гээд ярихаар уулзуулахгүй хүүхэд чамайг харахаараа эргэж буцаад хэцүү байна, дараа бол тэгж байгаад ир гээд уулзахад хэцүү болж эхэлсэн. Охинтойгоо уулзахын тулд Х аас гуйна, аргадна ингэсний эцэст хаяа нэг уулзана 2017 оноос хойш хаана байгаа нь тодорхойгүй утсаа авахгүй, бүх холбоо тасарсан. Энэ цаг хугацаанд охиноо авах гэж оролдоод гэрт нь очихоор Х гэртээ байдаггүй, гэрийнхэн нь болон охины эмээ гэх хүн огт уулзуулдаггүй уулзахаар очих үедээ хорооны ажилтан болон хариуцсан цагдаагийн ажилтныг хүртэл дуудан охиноо харж байсан удаа бий. Хамгийн гол зүйл нь миний ээж байх эрхийг удаан хугацаагаар хаасан охины ээжтэйгээ уулзах эрхийг хязгаарласан байдал нь хүний эрхийг ноцтой зөрчиж байна гэсэн гомдлыг гаргасан.

УДШ-ээс гомдлыг хангахгүй орхиж охиныг үргэлжлүүлэн эцгийн асрамжид үлдээхээр шийдвэрлэсэн бөгөөд тухайн шийдвэрийн үндэслэх хэсэгт дараах зүйлсийг тусгасан. Үүнд:

- Хэргийн баримтаас үзэхэд охин Ц төрсөн цагаас одоог хүртэл эцэг Х ын асрамжид хамт амьдарч, цэцэрлэгт явж байсан, одоо сургуульд сурдаг, эрүүл саруул, сэргэлэн цовоо өсөж байгаагийн зэрэгцээ шүүхээс томилсон шинжээчийн 3 удаагийн дүгнэлтийн эхний 2 нь эцэг эхийн аль алиных нь асрамжид үлдэх нь зохистой гэж гарсан байна. Харин 3 дахь удаа Монгол Улсын Засгийн Газрын Хэрэгжүүлэгч Агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар шинжээчээр томилогдсон ба 2023.07.24-ний өдрийн дүгнэлтэд охин Ц ыг эцэг, эхийн хэний асрамжид үлдээвэл зохистой талаар заагаагүй хэдий ч шинжээчийн багийн ерөнхий санал дүгнэлтэд хүүхдийн ээнэгшин дасан зохицох төлөв тестийн үр дүнгээр охин Ц аавдаа дасан зохицол илүү өндөр үзүүлэлттэй гэж тодорхойлжээ.
- Шинжээчдийн дүгнэлт, зохигчийн тайлбар, хэрэгт авагдсан баримтаас үзэхэд охин Ц ын одоо байгаа асрамжийг өөрчлөх ноцтой шалтгаан, түүний эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн, зөрчигдөж болзошгүй гэсэн нөхцөл байдал тогтоогдоогүй, түүнчлэн эцгийн асрамжид үлдэхэд харшлах, үгүйсгэх, ноцтой үндэслэл байгаа тухай баримтгүй тул эцэг, эхийн хэнд илүү ээнэгшин дассан, амьдрах орчин нөхцөлийг өөрчлөх нь зайлшгүй шаардлага байгаа эсэхийг харгалзан хүүхдийн асрамжийг шийдвэрлэсэн.
- Гэр бүлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэгт заасан үүргээ биелүүлэх, хариуцагч Х охин Ц-г эх Д тай уулзахад саад болохгүйг дурдах нь зүйтэй.

[mn/single_case/8692?daterange=2021-01-01%20-%202026-03-25&id=3&court_cat=1&bb=1](https://shuukh.mn/single_case/8692?daterange=2021-01-01%20-%202026-03-25&id=3&court_cat=1&bb=1).

²² Улсын дээд шүүхийн 2024 оны 06 сарын 18-ны өдрийн 001/XT2024/00142 тогтоол, https://shuukh.mn/single_case/10577?daterange=2021-01-01%20-%202026-03-25&id=3&court_cat=1&bb=1.

Жишээ 3. Шүүхээс хүүхдийг асран хамгаалах үүргийг хэрэгжүүлэх журмыг тогтоосон кейс

2022 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 03343 дугаар шийдвэрээр²³ нэхэмжлэгч Г болон хариуцагч Т-д холбогдох Хүүхдийн асрамж тогтоолгож, тэтгэлэг гаргуулах тухай нэхэмжлэлтэй иргэний хэргийг хянан шийдвэрлэсэн.

Шүүхээс талуудын гаргасан нэхэмжлэлийн шаардлагын дагуу хэргийг хянан шийдвэрлэхдээ дараах агуулга бүхий дүгнэлтийг гаргасан. Үүнд:

- Иргэн Г, Т нар охин Э-ийн асрамжийг шийдвэрлүүлэхдээ хүүхдээ асран хамгаалах, тэжээн тэтгэх, эрүүл чийрэг өсгөн бойжуулах болон хуулиар хүлээсэн бусад үүргээ хэрхэн хэрэгжүүлэх талаар харилцан тохиролцоогүй учир Гэр бүлийн тухай хуульд зааснаар шүүх эцэг Т-ын хувьд дараах байдлаар охин Э-г асран хамгаалах үүргийг хэрэгжүүлэх журмыг тогтоов.
- Сар бүр даваагаас бямба гараг хүртэл нэг удаа, сар бүр бямбаас ням гарагт хоёр удаа охин Э-г иргэн Т асрамждаа авч түүний сурч боловсрох, амралт чөлөөт цагийг ая тухтай өнгөрүүлэх, эрүүл мэндэд анхаарч, амарч сувилуулах буюу эрүүл чийрэг өсгөн бойжуулах үүргийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэв.

Дээрх шүүхийн практик жишээнүүдээс үзэхэд шүүхээс гэрлэлт цуцлалттай холбоотой хүүхдийн асрамжийг тогтоохдоо хүүхдийн нас, хэнд илүү ээнэгшин дассан байдал, амьдрах орчин, ахуйн нөхцөл, эцэг, эхийн халамж, хүмүүжил, шинжээчийн дүгнэлт зэрэг олон хүчин зүйлийг харгалзан үзэж шийдвэрлэж байгаа нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл, шүүх хүүхдийн асрамжийг тогтоохдоо хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангах зарчмыг баримтлан хэрэгт авагдсан нотлох баримтын хүрээнд дүгнэлт хийж шийдвэр гаргаж байна.

Гэвч шүүхийн шийдвэрүүдээс харахад хүүхдийг асрамжид аваагүй эцэг, эхийн хүүхэдтэйгээ уулзах, харилцах эрхийг хэрэгжүүлэх асуудал нь эрх зүйн нарийвчилсан зохицуулалтгүй байгаагаас шүүхийн шийдвэрт ерөнхий байдлаар "эцэг, эх нь хүүхэдтэй уулзах, харилцахад саад учруулахгүй байх үүрэгтэй" гэж тусгах төдий байна. Харин уг үүргийг нөгөө тал биелүүлэхгүй тохиолдолд ямар хариуцлага хүлээлгэх, уулзах эрхийг хэрхэн албадан хэрэгжүүлэх, ямар байгууллага хяналт тавих зэрэг асуудал тодорхой зохицуулалтгүй хэвээр байна. Иймд хүүхдийг асрамждаа авч үлдээгүй эцэг, эх хүүхэдтэйгээ уулзах эрхээ хэрэгжүүлж чадахгүй байх тохиолдолд шүүхийн шийдвэр бодит амьдрал дээр хэрэгжихгүй байх, улмаар хүүхдийн аль аль эцэг, эхтэйгээ харилцах эрх зөрчигдөх нөхцөл үүсэж байна.

Кейс 3-ын хувьд хүүхдийн асрамжийг шийдвэрлэхийн зэрэгцээ асрамжид үлдээгүй эцэг, эхийн хүүхэдтэй уулзах, асран хамгаалах үүргээ хэрэгжүүлэх тодорхой хуваарь, журмыг тогтоож өгсөн нь хүүхдийн аль аль эцэг, эхтэйгээ харилцах эрхийг хангах зорилготой шийдвэр болсон байна. Энэ нь шүүхээс хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах үүднээс асрамжийн асуудлыг зөвхөн нэг талд шилжүүлэх байдлаар бус, харин хүүхдийн хүмүүжил, хөгжилд эцэг, эхийн оролцоог хадгалах чиглэлээр шийдвэр гаргаж буй практик байгааг

²³ Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 03343 шийдвэр, <https://legaldata.mn/shiidver/huraangui/view/145>.



харуулж байна. Гэвч шүүхийн шийдвэрт хүүхэдтэй уулзах хуваарь, журам тогтоосон боловч уг журмыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага, албадан хэрэгжүүлэх механизмын талаар эрх зүйн тодорхой зохицуулалт байхгүй байна. Үүний улмаас шүүхийн шийдвэр бодит амьдрал дээр хэрэгжихгүй байх, нэг тал хүүхэдтэй уулзуулахгүй байх, улмаар хүүхдийн эцэг, эхтэйгээ харилцах эрх зөрчигдөх нөхцөл үүсэх боломжтой байна.

2. Гэрлэлт цуцлах холбоотой хүүхдийн асрамжийг тогтоох маргааныг шүүхээр хянан шийдвэрлэх үед үүсэж буй бусад асуудал:

Гэрлэлт цуцлалтын маргааныг шүүхээр шийдвэрлэх явцад хүүхдийн эцэг, эх хоорондын саналын зөрүүтэй байдал нь хүүхдэд үзүүлэх сөрөг дагаврыг улам бүр нэмэгдүүлдэг.²⁴ Нийслэлийн болон дүүргийн Хүүхэд гэр бүлийн хөгжлийн төвүүд, Хүүхдийн эрхийн үндэсний төв, Хүүхдийн төлөө газар зэрэг байгууллага хүүхдийг хэний асрамжид өгвөл зохистой байх зэрэг, эцэг, эхийн хэн нь хүүхдийг арай илүү харж хандаж чадах эсэх талаар дүгнэлт хийдэг хэдий ч, харамсалтай нь шинжээч нар нь энэ чиглэлийн мэдлэг, туршлагатай биш байгаа нь хүүхдийн эрхийг ноцтой зөрчиж байна.²⁵ Шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх явцад хүүхэдтэй холбоотой аливаа асуудлаар шинжээчийн дүгнэлт гаргуулах асуудалд ихээхэн бэрхшээл учирдаг. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар, хэлтсүүд шүүгчийн захирамжаар асран хамгаалалтын талаарх маргаанд шинжээчийн дүгнэлт гаргадаг хэдий ч хүүхдийн асуудлаар үнэн зөв бодитой дүгнэлт гаргах чадвартай мэргэжлийн болон мэргэшсэн шинжээчийн тоо бага, дүгнэлтийг хэрхэн гаргах талаар нэгдсэн арга зүй, журам батлагдаагүй, дүгнэлт гаргахтай холбогдон гаргах зардлыг хэн хэрхэн хариуцах нь тодорхойгүй, нөхцөл байдлын үнэлгээ болон дүгнэлттэй холбогдуулж эрүүл мэнд, боловсрол гэх зэрэг холбогдох байгууллагын дэмжлэг, үйлчилгээ авах шаардлагатай байдаг ч хүүхэд хамгааллын чиглэлээр хэрэгжүүлэх хамтын ажиллагаа тодорхой бус, тэдгээр нь хамтран ажилладаггүй, үзүүлэх үйлчилгээний төрөл, хэлбэр, хүртээмж, мэдээлэл ч хангалтгүй зарим тохиолдолд шинжээч хүчирхийлэл, дарамт, шахалтад өртдөг гэх зэрэг хүүхдийн асуудлаар дүгнэлт гаргах шинжээчийн үйл ажиллагаанд тулгамдаж байгаа зайлшгүй шийдвэрлэвэл зохих асуудлууд нэлээдгүй байна.²⁶

V. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Хүүхдийн асрамж тогтоох, хүүхэдтэй уулзах эрхийн эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судлах зорилгоор Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Бүгд Найрамдах Франц Улс болон Бүгд Найрамдах Солонгос Улсыг сонгон судалсан. ХБНГУ болон БНФУ нь ром германы эрх зүйн бүлд хамаарах бөгөөд Монгол Улсын эрх зүйн системтэй төстэй тул харьцуулах боломжтой гэж үзсэн. Харин БНСУ нь Ази тивийн улс орны хувьд гэр бүлийн харилцаа, нийгмийн онцлог Монгол Улстай ойролцоо бөгөөд гэр бүлийн шүүхийн тогтолцоо хөгжсөн, хүүхдийн

²⁴ Цэрэнпилийн Ичинхорлоо, Цэндийн Алтанцэцэг, Гэрлэлт цуцлалт ба хүүхдийн эрхийг хангах нь, Иргэний эрх зүйн онол, практик, (Улаанбаатар, 2017), 74 дэх тал.

²⁵ Алтангэрэлийн Батбаатар, Гэр бүлийн эрх зүйн зарим асуудал: Нэмж засварласан гурав дахь хэвлэл, (Улаанбаатар: 2021), 90–100 дахь тал.

²⁶ Цэрэнпилийн Ичинхорлоо, Цэндийн Алтанцэцэг, Гэрлэлт цуцлалт ба хүүхдийн эрхийг хангах нь, Иргэний эрх зүйн онол, практик, (Улаанбаатар, 2017), 77 дахь тал.



асрамж, уулзах эрх, тэжээн тэтгэх асуудлыг цогцоор нь зохицуулсан байдаг тул сонгон авч харьцуулан судалсан болно.

1. Бүгд Найрамдах Солонгос Улс

Бүгд Найрамдах Солонгос Улсын хувьд Иргэний хуулийн²⁷ 837 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт гэрлэгчид гэрлэлтээ цуцлуулах үед хүүхдийн асрамж, тэжээн тэтгэх болон бусад асуудлыг харилцан тохиролцож шийдвэрлэхээр заасан бөгөөд хэрэв талууд тохиролцоонд хүрээгүй бол Гэр бүлийн шүүх хүүхдийн асрамжийн асуудлыг шийдвэрлэнэ. Мөн эцэг, эхийн тохиролцоо нь хүүхдийн ашиг сонирхолд нийцээгүй гэж үзвэл шүүх уг тохиролцоонд өөрчлөлт оруулж болно гэж заасан. БНСУ-ын Иргэний хуулийн 837 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт хүүхдийг асрамждаа аваагүй эцэг, эх нь хүүхэдтэйгээ уулзах эрхтэй бөгөөд уулзалтын арга хэлбэр, хугацаа, давтамжийг шүүх тогтоож болохоор заасан.²⁸ Мөн хүүхдийн ашиг сонирхолд сөрөг нөлөөтэй гэж үзвэл шүүх уулзах эрхийг хязгаарлах, өөрчлөх, хасах шийдвэр гаргаж болно. Хүүхэд уулзахаас татгалзсан эсхүл эцэг, эхийн эрхээ хасуулсан тохиолдолд уулзах эрхийг хязгаарлах, хасах, мөн өөрчлөлтийг шүүх шийдвэрлэнэ. Түүнчлэн Гэр бүлийн шүүх хүүхдийн аюулгүй байдалтай холбоотойгоор зайлшгүй уулзах шаардлагатай гэж үзвэл хүүхэдтэй уулзах эрхийг хязгаарлахгүйгээр байж болно.

2. Бүгд Найрамдах Франц Улс

Асрамж тогтоох асуудлыг хувьд Шүүх нь гэр бүлийн асуудлыг шийдвэрлэхэд хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангахад онцгой анхаарал хандуулна. Хүүхэд ялган таних чадвартай буюу түүний эрх, ашгийг хамгаалах шаардлагатай үед хүүхдэд үзэл бодлоо илэрхийлэх эрхийг олгох бөгөөд энэ тохиолдолд хүүхэд маягт бөглөн шүүхэд хүсэлт гаргадаг байна. Хүүхдийн ашиг сонирхолд сөрөг нөлөө үгүй бол хүүхдийг ах, эгч нараас нь салгахгүй²⁹ гэж үздэг. Харин эцэг эхийнхээ хэн нэгэнтэй нь уулзах эрхийн хувьд эцэг, эх нь хүүхэдтэйгээ хувийн харилцаатай байх эрхтэй бөгөөд нөгөө тал нь туслах үүрэгтэй. Шүүх хүүхдийн эцэг, эхтэйгээ харилцах харилцааг тасралтгүй, үр дүнтэй байлгах арга хэмжээ авч болно.³⁰ Тухайлбал: эцэг, эх хоёулынх нь зөвшөөрөлгүйгээр хүүхдийг БНФУ-ын нутаг дэвсгэрээс гарахыг хориглох тухай захирамж гаргаж болно. Шүүх нь хүүхдийн ашиг сонирхлыг харгалзан эцэг, эхээс нь бусад этгээдтэй уулзах эрхийн нөхцөл, хугацааг тогтооно. Хүүхдийн асрамждаа үлдээсэн тал нь оршин суугаа газраа өөр газар шилжүүлсэн тохиолдолд 1 сарын дотор шинэ оршин суугаа газраа хувийн харилцаатай байх эрхтэй хүмүүст мэдэгдээгүй бол 6 сарын хугацаагаар хорих ял, мөн 7,500 еврогийн торгууль ногдуулна.

3. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

ХБНГУ-д хүүхдийн асрамж болон хүүхэдтэй уулзах эрхийг Иргэний хуулийн (Bürgerliches Gesetzbuch – BGB) гэр бүлийн эрх зүйн хэсэг буюу §§ 1626–1711 хэсгээр зохицуулдаг.³¹

²⁷ БНСУ-ын Иргэний хуулийн 837 дугаар зүйл, <https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#0000>.

²⁸ <https://marulaw.tistory.com/35>.

²⁹ Fr. Civ. Code art. 371-1, https://www.legifrance.gouv.fr/codes/article_lc/LEGIARTI000049294125.

³⁰ Fr. Civ. Code art. 371-2.

³¹ Bürgerliches Gesetzbuch (1896), <https://www.gesetze-im-internet.de/bab>.



Асрамж тогтоохтой холбоотойгоор Шүүх нь бага насны хүүхдийн эрх ашгийг хамгаалахад шаардлагатай тохиолдолд түүнд хамааралтай хүүхдийн асуудлаар мэргэжлийн хууль ёсны төлөөлөгчийг томилно. Эцэг, эх нь хүүхдийн хууль ёсны асрамжийн эрх, үүргийг эдэлж, хүүхдийн сайн сайхныг хамгаалах, эрүүл хөгжлийг дэмжих, түүний ашиг сонирхлыг харгалзан аливаа шийдвэр гаргахад анхаарах үүрэгтэй.³² Хэрэв эцэг, эх тусдаа амьдарч, хүүхдийн асрамжийн талаар тохиролцоонд хүрээгүй бол гэр бүлийн шүүх хүүхдийн сайн сайхны үндсэн дээр асрамжийг шийдвэрлэнэ."

Уулзах эрхийн хувьд "Хүүхэд эцэг, эхийн аль алинтайгаа харилцах, уулзах эрхтэй бөгөөд эцэг, эх нь хүүхэдтэйгээ уулзах, харилцах боломжийг хангах үүрэг, эрхтэй" гэж заасан байна.³³ Хүүхэд эцэг, эхийн аль алинтай уулзах эрхтэй. Мөн эцэг, эхийн аль аль нь хүүхэдтэйгээ уулзах үүрэгтэй бөгөөд эрхтэй. Шүүх нь хүүхдийн хэн хэнтэйгээ уулзахыг тогтоож, үүнийг хэрхэн хэрэгжүүлэх мөн үүргээ биелүүлэхийг шаардаж болно. Хүүхдийн эрх ашигт нийцсэн тохиолдолд өвөө, эмээ, ах, эгч, дүү нар нь хүүхэдтэй уулзах эрхтэй.

4. Харьцуулсан судалгааны үр дүн, дүн шинжилгээ

Дээрх улс орнуудын эрх зүйн зохицуулалтыг Монгол Улсын эрх зүйн зохицуулалттай харьцуулан үзэхэд хүүхдийн асрамж тогтоох асуудлыг шийдвэрлэх үндсэн шалгуур нь бүгд хүүхдийн дээд ашиг сонирхлыг хамгаалах зарчимд тулгуурлаж байна. Монгол Улсын нэгэн адил БНСУ, ХБНГУ, БНФУ-д хүүхдийн асрамжийн асуудлыг эцэг, эх харилцан тохиролцоо боломжтой бөгөөд тохиролцоонд хүрээгүй тохиолдолд шүүх шийдвэрлэдэг нийтлэг зохицуулалттай байна. Гэвч хүүхэдтэй уулзах эрхийн зохицуулалтын хувьд тодорхой ялгаа ажиглагдаж байна. Судлагдсан улс орнуудад хүүхэдтэй уулзах эрхийг зөвхөн хуульд тунхаглах бус, харин түүнийг хэрэгжүүлэх нөхцөл, хугацаа, давтамж, хяналтын механизмыг илүү нарийвчлан зохицуулжээ. Тухайлбал, БНСУ-д гэр бүлийн шүүх хүүхэдтэй уулзах арга хэлбэр, хугацаа, давтамжийг тогтоохоос гадна хүүхдийн ашиг сонирхолд нийцэхгүй гэж үзвэл уг эрхийг өөрчлөх, хязгаарлах бүрэн эрхтэй байна. Харин ХБНГУ-д хүүхэд эцэг, эхийн аль алинтайгаа харилцах эрхтэй болохыг хуульчилж, шүүх уулзалтын хэрэгжилтэд хяналт тавих боломжтой байдлаар зохицуулжээ.

БНФУ-ын хувьд хүүхдийн эцэг, эхтэйгээ харилцах эрхийг хамгаалахад илүү өндөр ач холбогдол өгч, хүүхдийн оршин суугаа газрын өөрчлөлтийн талаар мэдээлэх үүргийг хуульчилсан бөгөөд уг үүргийг зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэхээр зохицуулсан байна. Энэ нь хүүхдийн эцэг, эхтэйгээ харилцах боломжийг бодитоор хамгаалах зорилготой механизм гэж үзэж болно. Харин Монгол Улсад хүүхдийн асрамж тогтоох асуудлыг шийдвэрлэх үндсэн зохицуулалт бүрдсэн боловч хүүхэдтэй уулзах эрхийн хэрэгжилтийг хангах нарийвчилсан журам, албадан хэрэгжүүлэх механизм, хяналтын тогтолцоо хангалтгүй байна. Шүүхийн практикт хүүхэдтэй уулзахад саад учруулахгүй байх үүргийг шийдвэрт тусгадаг боловч уг үүргийг биелүүлээгүй тохиолдолд ямар

³² "Im Sinne des § 1626 BGB haben die Eltern die elterliche Sorge wahrzunehmen und dabei das Wohl des Kindes in den Mittelpunkt zu stellen." — BGB § 1626.

³³ "Nach § 1684 BGB hat ein Kind das Recht auf Umgang mit beiden Elternteilen; zugleich sind die Eltern verpflichtet, den Umgang zu ermöglichen." — BGB § 1684.



арга хэмжээ авах, ямар байгууллага хэрэгжилтэд хяналт тавих талаар тодорхой зохицуулалт дутмаг байна.

Иймд харьцуулсан судалгаанаас үзэхэд Монгол Улсад хүүхэдтэй уулзах эрхийг хэрэгжүүлэх нарийвчилсан журам тогтоох, шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангах албадан хэрэгжүүлэх механизмыг бий болгох, хүүхдийн эрх ашигт нийцээгүй тохиолдолд уулзах эрхийг өөрчлөх, хязгаарлах асуудлыг илүү тодорхой зохицуулах шаардлагатай байна. Түүнчлэн гэр бүлийн хэрэг маргааны онцлогт нийцсэн мэргэшсэн шүүхийн оролцоог нэмэгдүүлэх нь хүүхдийн эрхийг хамгаалах үр нөлөөг дээшлүүлэх ач холбогдолтой гэж үзэж байна.

VI. ДҮГНЭЛТ, САНАЛ

Асрамж болон асран хамгаалалтын мөн чанар, агуулгыг бүрэн ойлгоогүйгээс үүдэн хүүхдийг эцэг, эхийн хэн нэгний асрамжид үлдээх талаарх шүүхийн шийдвэрийг асран хамгаалалт тогтоогдсон мэтээр ойлгож хүүхдийн асуудлыг дангаараа бие даан шийдвэрлэх гэсэн эцэг, эхийн буруу хандлага практикт ажиглагдаж байна. Хуульд заасан "Эцэг, эхийн хэн нэгний асрамжид үлдээх" гэх ойлголт нь хүүхдийг асрах үйлийн утгыг илэрхийлэх бол асран хамгаалалт нь хүүхдийг хууль зүйн хувьд тодорхой этгээдийн хамгаалалтад өгөх утгыг илэрхийлнэ. Тийм ч учраас хүүхдийн эцэг, эх гэрлэлтээ цуцлуулсан буюу эсхүл хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар хүүхдээсээ тусдаа амьдарч байгаа нөхцөлд хуульд заасан эцэг, эхийн үүргээс чөлөөлөгдөхгүй, түүнчлэн эцэг, эхийн хэн нэг нь нөгөөдөө хүлээсэн үүргээ биелүүлэхэд нь саад болохыг хориглодог. Харьцуулан судалсан улс орнуудад гэр бүлийн хэрэг маргааныг Гэр бүлийн шүүхэд харьяалан шийдвэрлэж байна. Гэр бүлийн шүүх талууд насанд хүрээгүй хүүхэдтэй эсэх, хүүхэдтэй бол хууль ёсны асран хамгаалагч, хүүхдийг тэжээн тэтгэх талаарх тохиролцоо, тэтгэлгийн хэмжээ, хүүхэдтэй уулзах болзол нөхцөл, эцэг, эх байх үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой бүхий л тохиролцоог харгалзан үзэж шийдвэр гаргадаг байна.

Энэхүү судалгаагаар Монгол Улсад гэрлэлтийг шүүхийн журмаар цуцлах үед хүүхдийн асрамж тогтоох болон хүүхэдтэй уулзах эрхийн эрх зүйн зохицуулалт, шүүхийн практикт тулгамдаж буй асуудлыг судаллаа. Судалгааны хүрээнд хүүхдийн асрамж тогтоох үндэслэл, хүүхдийн дээд ашиг сонирхлын зарчмын хэрэгжилт, хүүхэдтэй уулзах эрхийн зохицуулалт болон харьцуулсан эрх зүйн судалгааг голлон авч үзсэн болно. Харин гэрлэлт цуцлалтын дараах хамтын асрамжийн тогтолцоог Монгол Улсад нэвтрүүлэх боломж, хүүхдийн сэтгэл зүйн нөхцөл байдлыг асрамж тогтоох ажиллагаанд үнэлэх аргачлал, гэр бүлийн дагнасан шүүх байгуулах хэрэгцээ шаардлага, хүүхэдтэй уулзах эрхийн хэрэгжилтийн бодит үр нөлөө болон статистик судалгааг энэхүү ажлын хүрээнд нарийвчлан авч үзээгүй болно. Иймд цаашид хүүхдийн хамтын асрамжийн эрх зүйн загвар, хүүхдийн асуудлаар мэргэшсэн шинжээчийн үнэлгээний тогтолцоо, гэр бүлийн шүүхийн институцийн хөгжил, хүүхэдтэй уулзах эрхийн хэрэгжилтэд хяналт тавих эрх зүйн механизмын талаар бие даасан, гүнзгийрүүлсэн судалгаа хийх шаардлагатай байна.



Хүүхдийн эрхийг хамгаалах нь зөвхөн хүүхдийн оролцоо, эцэг эхийн үүрэг хариуцлагад бус, шүүхийн шийдвэрийн хэрэгжилт, холбогдох байгууллагуудын хамтын ажиллагаанд шууд хамааралтай. Иймд Монгол Улсын эрх зүйн зохицуулалтыг хүүхдийн дээд ашиг сонирхлыг хамгаалах зарчимд нийцүүлэн сайжруулах, шүүхийн шийдвэрийн хэрэгжилт болон эцэг эхийн үүрэг хариуцлагыг тодорхой болгох шаардлага нэн тэргүүнд тавигдаж байна.

Санал:

Хуулийн зохицуулалтыг сайжруулах хүрээнд:

1. Хүүхдийг эцэг, эхтэй нь байнгын харилцаатай байлгах, уулзах, эцэг, эхийнхээ талаар бодитой үнэн зөв мэдээлэл авах боломж нөхцөлөөр хангахыг даалгах, хүүхдийн хүмүүжил боловсролын асуудалд оролцохыг үүрэг болгох, хүүхдийг аюулгүй орчинд асарч, хүмүүжүүлэхийг үүрэг болгох зэрэг хүүхдийн эрх, ашгийг хамгаалах нэн тэргүүнд хэрэгжүүлж болох хуулиар хүлээсэн үүргийг шүүхийн шийдвэрт тусгайлан заах шаардлагатай байна.
2. Хүүхдийн уулзах эрхийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын механизмыг хуульд тусгах.

Шинжээч, мэргэжилтнүүдийн дэмжлэгийг сайжруулах хүрээнд:

1. Хүүхдийн асуудалд мэргэжлийн шинжээчийн дүгнэлт, сэтгэл зүйч, сурган хүмүүжүүлэгчийг татан оролцуулах эрх зүйн механизм бий болгох.
2. Шинжээчийн дүгнэлт гаргах стандартыг тогтоож, шинжээчийн сургалт, туршлагыг сайжруулах.



НОМ ЗҮЙ

1. Эрх зүйн эх сурвалж:

1. Хүүхдийн эрхийн тухай конвенц, 1989 он.
2. Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он.
3. Гэр бүлийн тухай хууль, 1999 он.
4. Улсын Дээд шүүхийн 2021 оны 12 сарын 07-ны өдрийн 001/ХТ2021/01479 дугаар тогтоол.
5. Улсын Дээд шүүхийн 2024 оны 06 сарын 18-ны өдрийн 001/ХТ2024/00142 дугаар тогтоол.
6. Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 101ШШ2022/03343 дугаар шийдвэр.

2. Монгол хэл дээрх эх сурвалж:

1. Авирмэдийн Дугармаа, Монгол Улсын гэр бүлийн эрх зүй: Онол, бодлого, сорил, нэр томьёо, 2016 он.
2. Алтангэрэлийн Батбаатар, Гэр бүлийн эрх зүйн зарим асуудал (Нэмж засварласан гурав дахь хэвлэл), 2021 он.
3. Цэрэндамбын Ганцэцэг, Гэр бүлийн салалтаас үүссэн хүүхдийн түгшүүрийг проектив аргаар судалсан нь \6 настай хүүхдийн жишээн дээр\, Сэтгэл судлалын магистрын ажил, 2017 он.
4. Авирмэдийн Дугармаа, Гэр бүлийн эрх зүй, 2016 он.
5. Төмөрийн Батцэнгэл, Батын Бандихүү, Гэр бүлийн сэтгэл судлал, 2012 он.
6. Цэндийн Алтанцэцэг, Гэр бүлийн эрх зүй, 2007 он.
7. Чимэдийн Отгонбаяр, Гэр бүлийн эрх зүй, 2006 он.
8. Цэрэнпилийн Ичинхорлоо, Цэндийн Алтанцэцэг, Гэрлэлт цуцлалт ба хүүхдийн эрхийг хангах нь, Иргэний эрх зүйн онол, практик, 2017 он.

3. Гадаад хэл дээрх эх сурвалж:

1. Hilaire Barnett, (2021), Children's Rights and the Law: An Introduction 1st Edition, <https://www.perlego.com/book/2977126/childrens-rights-and-the-law-an-introduction-pdf>
2. Wallerstein, J.S. (1985b). The Overburdened Child5 Some Long-term Consequences of Divorce, Columbia Journal of Law and Social Problems, 19 (2), <https://scispace.com/papers/the-overburdened-child-some-long-term-consequences-of-4m3jcwnmks>
3. Washington State Parenting Act, 1987
4. Marie Julie, 2023, Family Rights5 Protecting the Best Interests of Children: Family Law and Child Welfare, https://www.researchgate.net/publication/396053038_Family_Law_and_the_Best_Interests_of_the_Child_Standard_Developing_Incorporating_the_Mental_Health_Cultural_History_and_the_Voice_of_the_Child_in_Custody_Determinations
5. БНСУ-ын Иргэний хуулийн 837 дугаар зүйл, <https://www.law.go.kr/lsInfoP.do?>



IsiSeq=251069&efYd=20240517#0000

6. <https://marulaw.tistory.com/35>
7. Fr. Civ. Code art. 371-1, https://www.legifrance.gouv.fr/codes/article_lc/LEGIARTI0000049294125

4. Цахим эх сурвалж

1. Монгол Улсын эрх зүйн мэдээллийн цахим систем: <https://legalinfo.mn/mn>
2. Шүүхийн ерөнхий зөвлөлийн цахим хуудас: https://www.judcouncil.mn/site/news_full/15378
3. Улсын дээд шүүхийн цахим хуудас: <http://old.supremecourt.mn/act/view/244>
4. ХБНГУ-ын эрх зүйн мэдээллийн цахим сан: <https://www.gesetze-im-internet.de/bgb/>



Article

Бүтээл
•
Хууль
•
Хууль
•
Хууль

Improving the Legal Framework for Child Custody Determinations in Divorce Proceedings

OYUNTUNGALAG Battulga*

Abstract: This study examines the legal framework governing child custody determinations and visitation rights in judicial divorce proceedings in Mongolia and explores ways to improve the existing regulations. The research analyzes the Constitution of Mongolia, the Family Law of Mongolia, the United Nations Convention on the Rights of the Child, and other relevant legal instruments. In addition, judicial decisions were reviewed to assess the practical implementation of the applicable legal provisions.

Furthermore, a comparative legal analysis was conducted by examining the legal regulations concerning child custody and visitation rights in the Republic of Korea, the Federal Republic of Germany, and the French Republic, and comparing them with the legal framework of Mongolia.

The findings indicate that Mongolian legislation establishes fundamental criteria for determining child custody based on the principle of the best interests of the child, including conditions for judicial decision-making and consideration of the child's views. Judicial practice demonstrates that factors such as the child's age, upbringing, living environment, parental care, and expert opinions are taken into account when resolving custody disputes. However, the legal framework remains insufficient with respect to the procedures and frequency of exercising visitation and communication rights by the non-custodial parent, mechanisms for monitoring compliance, and legal measures for enforcing court decisions. As a result, the child's right to maintain regular contact and personal relations with both parents is not fully guaranteed.

The comparative analysis reveals that the jurisdictions studied have enacted detailed regulations governing visitation rights, judicial supervision, and accountability mechanisms to ensure compliance, thereby providing effective protection of children's rights. Accordingly, it is necessary for Mongolia to establish specific procedures for the implementation of visitation rights, strengthen legal mechanisms for the enforcement of court decisions, and increase the involvement of specialized experts and child psychologists in matters concerning children.

Keywords: Divorce, judicial divorce proceedings, child custody determination, best interests of the child, visitation rights.

* 5th grade student of School of Law, National University of Mongolia.